



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 26 өдөр

Дугаар 1/2017

Мандалговь


Баяр наадмын зардал шилжүүлэх тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.3 дах заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймаг байгуулагдсаны 76, Их номч бандида Зава Дамдины мэлмий гийсэний 150 жилийн ойд зориулсан “Алтан дэвтэр” даншүг, Их Мандал говийн бүсийн хурдан морины уралдаан, Нарны хүлэг уяачдын холбооны 20 жилийн ойд зориулсан баяр наадам 2017 оны 07 дугаар сарын 28-30-ны хооронд болохтой холбогдуулан Орон нутгийн хөгжлийн сан дах аймгийн баяр наадмын зардал 10 000 000 /Арван сая/ төгрөгийг Орон Нутгийн Өмчит Нийтлэг Үйлчилгээ Үйлдвэрийн Газрын 5466043925 тоот дансанд шилжүүлсүгэй.

Хоёр. Баяр наадмын зардал 10 000 000 /Арван сая/ төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж тайлагнахыг ОНӨНҮҮГ-ын дарга Б.Наранцэцэгт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О БАТ-ЭРДЭНЭ

0200755